

**ГОЛ МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ
АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ТҮҮНИЙГ
ДАГАН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**



ХУУЛЬ АНХ БАТЛАГДСАН

Энэ хуулийн зорилго, үзэл санаа нь байгаль орчноо хамгаалах, онгон төрхийг хадгалахад чиглэсэн маш зөв хууль гарсныг нийгэм даяар ухамсарлаж, хүлээн зөвшөөрсөн.

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр дагаж мөрдөх журмын тухай хуулийн хамт батлагдан гарсан.



ECOLOGY versus POLLUTION


www.shutterstock.com · 107934563



Хууль хэрэгжих үе шат



Хуульд хамрагдсан тусгай зөвшөөрлүүдийн шийдлийн талаарх схемчилсэн загвар



Доорх шийдэлд хүрэх нь:

1. Урсац бүрэлдэх эх тусгай хамгаалалтанд авна.
2. Ой модоо хамгаална.
3. Голын эргээс 200м бүс тогтоож, БО-ны асуудлаар хатуу гэрээний дагуу явуулна.
4. Хууль эргэж үйлчлэхгүй, нөхөн төлбөрийн асуудлаас хөнгөлөгдөнө.

Ашиглалтын 395 тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын төрөл, нөөцөөр үзүүлбэл:

д/д	Ашигт малтмалын төрөл/хэмжих нэгж/	Тусгай зөвшөөрлийн тоо	ААН-ийн тоо	Нөөцийн хэмжээ,	Өмнө үйл ажиллагаа явуулж байсан ТЗ	Ашиглалтын жил
1	Алт, тн-оор	213	128	63,4 тн	24	2-8
2	Барилгын материал, /сая.м3- ээр/	89	83	Элс хайрга-80 шавар-10 дайрга-30	44	3-26
3	Нүүрс, /сая.тн-оор/	46	33	5450.0	30	11-30
4	Төмрийн хүдэр, /сая. тн-оор/	8	8	238.6	5	5-10
5	Тугалга /мян.тн/	11	11	602.6	4	5-10
6	Гянтболд/тн-оор/	8	8	1370.0	4	5-12
7	Жонш /сая.тн-оор/	5	5	2.3		
8	Бусад	28	19			
	Нийт тоо	395	289		130	

Хуулийн нэмэлт өөрчлөлтөөс

Гарах үр дүн

Орхигдсон 2130 га талбайд нөхөн сэргээлтийн стандарт, норм, шаардлагын дагуу нөхөн сэргээлт хийгдэнэ.

Голын урсац бүрэлдэх эх бүрэн хамгаалагдана.



Гадаадын хөрөнгө оруулагчдад эерэг хандлага өгч оруулалт хэр тэрбум төгрөгөөр өснө. 400 орчим

Уг хуулийг тойрсон удаан хугацааны хүлээлт, ойлгомжгүй байдал арилна.



ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД:

- Хууль батлагдахаас өмнө /2009 оны/ олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсвэл энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өргөдөл гаргана.



ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

1

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийлгүй орхисон тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд гаргах зардлыг ашиглалт явуулсан хугацаанд олсон орлоготой нь уялдуулан нөхөн гаргуулна.

2

Хуулийн хугацаанд өргөдөл ирүүлээгүй болон гэрээ байгуулаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахаар тус тус зохицуулсан болно.

3


Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт болон хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн бол тусгай зөвшөөрлийг цуцлахаар Ашигт малтмалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан болно.



ШИЙДЭЛ, БОЛОМЖ

Хууль батлагдсанаар гол мөрний урсац бүрэлдэх эх бүрэн хамгаалагдаж, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд уул уурхайн үйл ажиллагааг уул уурхайн үйлдвэрлэлд өртсөн газар нөхөн сэргээгдэж, цаашид хуулиар хориглосон газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгогдохгүй болох бөгөөд Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Хууль эргэж үйлчлэхгүй байх, адил тэгш үйлчлэх ардчилсан нийгмийн зарчимд тулгуурлан хувийн хэвшилд дэмжлэг үзүүлж, нэг удаагийн боломжийг олгон, Төр, олон нийтийн хяналтан дор хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нөхцөлөөр хангагдана.





Анхаарал тавьсанд баярлалаа!

Та дээрх хуулиудын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл www.legalinfo.mn хаягаар орж үзнэ үү.

